



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Ардчилсан намын даргаар
бүртгүүлэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Баярмаа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ардчилсан намын даргаар Л.Гантөмөр, Д.Ганбат нарыг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Г.Банзрагч, П.Соёл-Эрдэнэ нарын илтгэснээр, хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг. Иргэн Л.Гантөмөр, Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга гэх Ч.Өнөрбаяр нар "...Намын Үндэсний бодлогын хорооны ээлжит бус хурал 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр хуралдаж, Үндэсний бодлогын хорооны болон намын ээлжит бус Их хурлыг товлосон. Үндэсний бодлогын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар Л.Гантөмөрийг намын даргаар сонгогдсонд тооцож, мөн өдрийн намын ээлжит бус Их хурлаар батламжилсан тул Ардчилсан намын даргаар Л.Гантөмөрийг бүртгүүлэх" өргөдлийг гаргаж, 5 хавтас, 1158 хуудас баримт ирүүлжээ.

Дээрх өргөдөлтэй холбогдуулж, Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга гэх Д.Эрдэнэсүвд: "...2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр дээрх бүлэг этгээдүүд намын Үндэсний бодлогын хорооны гишүүдийн хурал нэртэй дүрмийн бус үйл ажиллагааг, хууль бус бүрэлдэхүүнтэйгээр буюу Үндэсний бодлогын хороонд бүртгэлгүй, саналын эрхгүй хүмүүсээр олонхийг бүрдүүлэн хуралдуулж, Ардчилсан намын Үндсэн дүрмийн хэд хэдэн заалтыг санаатайгаар зөрчин, намын Их хурал нэртэй арга хэмжээ зохион байгуулж, улмаар намын даргаар Л.Гантөмөрийг хууль бусаар сонгосон байна. Тиймээс "Эвлэрлийн" гэх тодотголтой хууль бус үйл ажиллагаанд Үндэсний бодлогын хорооны саналын эрхтэй гишүүдийн 50 буюу түүнээс дээш хувь нь оролцоогүй тул дүрмийн бус үйл ажиллагаа юм. Мөн Их хурлын төлөөлөгч сонгох үйл ажиллагааг Ардчилсан намын Дотоод сонгуулийн хорооны Д.Алтанхуяг даргатай хороо зохион байгуулаагүй тул Их хурал гэх үйл ажиллагаа нь бүхэлдээ дүрэм зөрчсөн хүчин төгөлдөр бус үйл ажиллагаа юм.

Намын даргаар С.Эрдэнийг бүртгэсэн шийдвэр хүчин төгөлдөр үйлчилж байна” гэж, 4 хуудас баримт ирүүлсэн.

Мөн Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга гэх И.Мөнхжаргал: “...Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг нь Үндэсний бодлогын хорооны ээлжит бус хуралдаан зарлах эрхгүй. Намын анхан шатны гишүүдийн намын дарга сонгох эрхэд халдаж, зөвхөн Үндэсний бодлогын хорооны хэмжээнд даргын сонгууль явуулах санаа өвөрлөн, эрх бүхий этгээд зарлаагүй, ирц нь бүрдээгүй, дүрмийн бус хуралдаанаас батлан гаргасан “Намын дарга сонгох” журам хүчин төгөлдөр бус юм. Намын анхан шатны байгууллагын дийлэнх олонх нь Их хурлын төлөөлөгч сонгох хурлаа хийгээгүй, Их хурлын төлөөлөгчид хэрхэн сонгогдсон нь тодорхойгүй. Ардчилсан намын дарга Х.Баттулга хурал зарлаагүй, Ардчилсан намын гэрчилгээ намын төв байранд эх хувиар хадгалагдаж байгаа тул бүртгүүлэхээр материал бүрдүүлж буй этгээд нь улсын бүртгэлийн гэрчилгээг хуурамчаар үйлдсэн байх магадлалтай” гэж, тайлбар хүргүүлэх тухай 40 хуудас баримтыг тус тус хавсарган ирүүлсэн байна.

Хоёр. Ардчилсан намын дарга гэх С.Эрдэнээс “Ардчилсан намын ээлжит бус XVI Их хурал 2023 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж, Ардчилсан намын даргын 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн цахим сонгуульд 2022.34 оноогоор ялалт байгуулсан Дашдондогийн Ганбатыг намын даргаар ёсчлон батламжлах асуудлыг хэлэлцэж батламжилсан тул Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг гаргаж байна” гэх өргөдлийг 4 хавтас бүхий 1311 хуудас баримтын хамт ирүүлжээ.

Дээрх өргөдөлтэй холбогдуулж, Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга гэх И.Мөнхжаргалаас “... С.Эрдэнэ намын даргын сонгууль зарлах эрхгүй, С.Эрдэнийн үед Дотоод сонгуулийн хорооны даргаар ажиллаж байсан Х.Алтанхуяг нь намын даргын дүрмийн дагуу огцорсон тул Х.Алтанхуяг даргатай гэх Дотоод сонгуулийн хороо намын дотоод сонгууль зарлах эрхгүй, цахим сонгууль гэгч нь хүчингүй, дүрмийн бус Их хурал явагдсан...” гэх зэрэг үндэслэлээр тайлбар, мэдээлэл ирүүлсэн.

Иргэн Л.Гүндалайгаас “... С.Эрдэнэ нь 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Ардчилсан намын даргын сунгаа гэгч зүйлийг зарлан зохион байгуулж нэр дэвшсэн хүн бүрээс урьд өдөр нь 35 сая төгрөгийг дэнчин хэмээн хураан авч, цахим сонгууль хэмээх хуурамч үйл ажиллагааг зохион байгуулж нэр дэвшигчдийг удаа дараа хууран мэхэлж, өөртөө санхүүгийн ашигтай давуу байдал олж авсан. Энэ гэмт хэргийн хохирогч болсон миний бие С.Эрдэнийн гэмт үйлдлийг шалгуулахаар хуулийн байгууллагад өргөдөл гаргасан. Хэрвээ С.Эрдэнийн энэхүү цахим сонгууль нь зохион байгуулалттай гэмт хэрэг гэдэг нь нотлогдвол С.Эрдэнийн зохион байгуулсан 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Ардчилсан намын даргын сунгаа гэгч нь хууль бус болох юм. Иймээс энэхүү сунгаагаар ялагч болж Ардчилсан намын даргаар нэрээ бүртгүүлэхээр Улсын дээд шүүхэд хандаж байгаа Д.Ганбатын өргөдлийг хуулийн байгууллага шалгаж үнэнийг тогтоотол хүлээн авахгүй байна уу” гэжээ.

Мөн Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга гэх Ч.Өнөрбаяраас “Ардчилсан нам нь Улс төрийн намын тухай хууль, Ардчилсан намын Үндсэн дүрэмд

нийцүүлэн намын даргаа сонгон, ёсчлон батламжилж Л.Гантөмөрийг намын даргаар бүртгүүлэх өргөдөл гаргасан. ...Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаа дууссан байхад цахим сонгууль гэгчийг Ардчилсан намын дүрэмд байхгүй байдлаар зохион байгуулсан нь хүчингүй, намын бүтцийн байгууллагуудын хурлын ирц хүрээгүй тул хүчин төгөлдөр бус, Ардчилсан намын Үндсэн дүрмийг зөрчсөн тул хүлээн авч шийдвэрлэх үндэслэлгүй байна. Иймд С.Эрдэнээс ... Ардчилсан намын даргаар Д.Ганбатыг бүртгүүлэхээр ирүүлсэн өргөдлийг Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 3.3-т заасны дагуу Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэхгүй буцааж шийдвэрлэж өгөхийг хүсье...” гэсэн хүсэлтийг тус тус ирүүлсэн байна.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дараах үндэслэлээр Ардчилсан намын даргаар Л.Гантөмөрийг бүртгүүлэх өргөдлийг хангаж, Д.Ганбатыг бүртгүүлэх өргөдлийг хангахаас татгалзаж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1-д “... намын даргын гарын үсэг бүхий өргөдөл” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1-д “намын дотоод зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог намын дүрмээр зохицуулна”, 21 дүгээр зүйлийн 21.2-т “намын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлт нь Үндсэн хууль, энэ хуультай нийцэж байгаа эсэхэд Улсын дээд шүүх хяналт тавина ...” гэж тус тус зааснаар намын даргыг сонгож, баталсан үйл ажиллагаа хууль болон тухайн намын дүрэмд нийцсэн эсэхийг хянан үзэв.

Нэг. Л.Гантөмөрийг бүртгүүлэх өргөдлийн тухайд:

Ардчилсан намын үндсэн дүрмийн 5.13.13-т Үндэсний бодлогын хороог шаардан хуралдуулах харилцааг зохицуулсан бөгөөд 5.13.13.1-д “Намын дарга эсвэл Үндэсний бодлогын хорооны дарга, Үндэсний бодлогын хорооны 1/3-ээс доошгүй гишүүдийн шаардлагаар 14 хоногоос хэтрүүлэхгүйгээр зарлан хуралдуулах үүрэгтэй” гэж заасан. Энэ дагуу Үндэсний бодлогын хорооны 167 гишүүнээс Үндэсний бодлогын хорооны ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах шаардлага¹ гаргасан нь дүрмийн дээрх заалтад нийцсэн байна.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 38 дугаар тогтоолд “...Улсын дээд шүүхэд хадгалагдаж байгаа Ардчилсан намын улсын бүртгэлийн баримтууд болон хүсэлтэд хавсаргаж ирүүлсэн баримт бичгүүдийг тулгаж үзэхэд Үндэсний бодлогын хорооны гишүүд (Ардчилсан намын VIII Их хурлын 2017 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан 389 гишүүн)” гэж дүгнэсэн нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримт тул хурлын хүчин төгөлдөр байдлын ирцийг 389 гишүүнээс тооцно.

2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Үндэсний бодлогын хороо 244 гишүүнтэй хуралдсан ба үүнийг бүртгэлтэй гишүүдтэй тулгаж үзэхэд 201 гишүүн тухайн өдрийн

¹ 1 хавтас, 208 хуудас баримт, 201-205 хуудас

хуралдаанд оролцсон болох нь Ирцийн мэдээлэл² болон Үндэсний бодлогын хорооны гишүүдийн жагсаалт³ баримтаар тогтоогдов.

Намын дүрмийн Дөрөвдүгээр бүлэгт “намын шийдвэр гаргах зарчим”-ыг зохицуулахдаа 4.3.5-д “Хурлын ирц дараах байдлаар бүрдэнэ” гээд, 4.3.5.1-д “Бүх шатны намын байгууллагын хурлын хувьд Үндсэн дүрэм, бусад журамд өөрөөр заагаагүй бол таслах эрхтэй нийт гишүүдийн ердийн олонхи” гэж заасан. Иймээс 389 гишүүний ердийн олонхи 196 гишүүн байхаас 201 гишүүн ирсэн нь хурлын ирц дүрэмд заасан шаардлагад нийцсэн байна.

Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “дотоод асуудлаа ардчилсан зарчмыг баримтлан олонхийн саналаар шийдвэрлэх” гэж аливаа намын үйл ажиллагаандаа баримтлах зарчмыг тодорхой заасан.

Намын дүрмийн 5.13.1.1-д “Намын дүрмээр зохицуулах намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг намын эрх бүхий байгууллага буюу Үндэсний бодлогын хороо шийдвэрлэнэ” гэж зааснаар дотоод маргаанаа шийдвэрлэх зорилгоор “Намын даргыг сонгох” журам баталж, намын даргын сонгуулийг зохион байгуулах комисс байгуулж, нэр дэвшигчдэд тавигдах шаардлагыг тогтоож, бүртгэх ажиллагааг эхлүүлж, Үндэсний бодлогын хорооны болон намын ээлжит бус Их хурлын товыг тогтоосон нь Үндэсний бодлогын хорооны эрх хэмжээний хүрээнд байна.

Намын дүрмийн 5.13.12.27-д “Үндэсний бодлогын хороо нь намын Үндсэн дүрэмд нийцүүлэн дараах журмуудыг баталж мөрдүүлнэ” гээд, 5.13.12.27.9-д “Ардчилсан намын Дотоод сонгуулийн хорооны тухай” гэж заасан тул Үндэсний бодлогын хороо Намын даргыг сонгох журам батлах эрхтэй, нөгөө талаар намын дүрмийн 5.9.11-д “Намын анхан шатны байгууллагын саналын эрх нь нээлттэй гишүүд бүх шатны намын дарга, ҮБХ-ны гишүүн, нийслэл, дунд шатны намын хорооны гишүүний сонгууль, Ерөнхийлөгч болон бусад төрлийн сонгуульд нэр дэвшигчийг тойргийн зарчмаар тодруулахад санал өгнө” гэж заасантай зөрчилдөхгүй гэж үзлээ.

Учир нь намын дүрмийн 5.9.11-д “... саналын эрх нь нээлттэй гишүүд бүх шатны намын дарга...-ын сонгуульд нэр дэвшигчийг тойргийн зарчмаар тодруулахад санал өгнө” гэсэн, өөрөөр хэлбэл шууд сонгохоор заагаагүй, иймд Ардчилсан намын дүрэмд дээрх байдлаар намын даргыг тодруулах ажиллагааг өөр өөр арга замаар зохицуулж болохоор заасан бөгөөд нийт гишүүдээс санал авах хэлбэрээр, эсхүл Үндэсний бодлогын хорооноос санал гаргах хэлбэрээр тодруулж болохоор зохицуулсан байна.

Намын дүрмийн 5.12.2-т “... Их хурлын ээлжит, ээлжит бус хуралдааныг Үндэсний бодлогын хорооны нийт гишүүдийн ердийн олонхи (50-аас дээш хувийн)-ийн саналаар эсхүл Намын дарга зарлан хуралдуулна” гэж заажээ.

² 2 хавтас, 41-71 хуудас

³ Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны үүсгэн байгуулагдсан баримт бичиг, боть-4

2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн Үндэсний бодлогын хорооны хуралдаанд 249 гишүүн ирсэн нь Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор бүртгэсэн Үндсэн дүрэмд заасан хурал хүчин төгөлдөр байх ирцийн шаардлага хангасан, тухайн хуралд оролцсон 293 гишүүний олонх буюу 51.88 хувийн саналыг нэр дэвшигч Л.Гантөмөр авсан байна.

Намын дүрмийн 5.12.4-т “Их хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ”. Үүнд: 5.12.4.8-д “Намын даргыг ёсчлон батламжлах” гэж тус тус зааснаар 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр намын Их хурал 1009 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй хуралдаж, намын даргаар Л.Гантөмөрийг сонгогдсоныг 100 хувийн саналаар ёсчлон батламжилсан нь дүрмийн дагуу болжээ.

Их хурлын 1009 төлөөлөгчийн 302 нь Үндэсний бодлогын хороог төлөөлж, 9 нь Улсын Их Хурлын гишүүн, Дотоод сонгууль, Үндсэн дүрмийн хорооноос 7 гишүүн, 502 төлөөлөгч орон нутгийг төлөөлж, 189 төлөөлөгч дүүргийг төлөөлж оролцсон нь Намын дүрмийн 5.12.3-т “Их хурлын төлөөлөгчид нь сонгогдох, томилогдох зарчмаар бүрдэх бөгөөд өөрөөр шийдээгүй бол Нийслэлд дүүргийн хороо тус бүрээс 2, аймагт 10000-аас дээш хүн амтай сумын баг бүрээс 1, бусад сумдаас тус бүр 1 төлөөлөгч сонгох ба Намын дарга, ҮБХ, ҮДХ, ДоСХ-ны гишүүд, намын дэргэдэх байгууллагын гүйцэтгэх удирдлага томилогдоно” гэж заасанд нийцсэн байна.

Дүрмийн 5.9.10-т “Анхан шатны намын байгууллагын бүх гишүүдийн хурлаас намын Их хурлын төлөөлөгчийг сонгож, намын хорооны гишүүнийг тодруулна” гэж заасан, шүүхээс түүврийн аргаар 103 төлөөлөгчийг сонгож, хянан үзэхэд 74 хувь нь “намын үүр хуралдаж төлөөлөгчөөр сонгосон, хоорондоо ярилцаж байгаад намайг төлөөлөгчөөр явуулах болсон” гэсэн тул намын дүрмийн дээрх шаардлагыг хангасан гэж үзэв.

Иймээс Үндэсний бодлогын хорооны хурал, намын ээлжит бус Их хурал нь намын дүрэмд заасан шаардлагыг хангасан, эрх хэмжээний хүрээнд асуудлыг шийдвэрлэсэн байх тул намын даргаар Л.Гантөмөрийг бүртгэх үндэслэлтэй байна.

Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга гэх Д.Эрдэнэсүвдын “... Үндэсний бодлогын хороонд бүртгэлгүй, саналын эрхгүй хүмүүсээр олонхийг бүрдүүлэн хуралдуулж, Ардчилсан намын Үндсэн дүрмийн хэд хэдэн заалтыг санаатайгаар зөрчин, намын Их хурал нэртэй арга хэмжээ зохион байгуулж, улмаар намын даргаар Л.Гантөмөрийг хууль бусаар сонгосон” гэсэн хүсэлт, мөн Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга гэх И.Мөнхжаргалын “... Намын анхан шатны гишүүдийн намын дарга сонгох эрхэд халдаж, зөвхөн Үндэсний бодлогын хэмжээнд даргын сонгууль явуулах санаа өвөрлөн, эрх бүхий этгээд зарлаагүй, ирц нь бүрдээгүй, дүрмийн бус хуралдаанаас батлан гаргасан “Намын дарга сонгох” журам хүчин төгөлдөр бус юм. Намын анхан шатны байгууллагын дийлэнх олонх нь Их хурлын төлөөлөгч сонгох хурлаа хийгээгүй” гэсэн хүсэлт нь дээр дурдсан үйл баримтаар няцаагдсан тул хангах үндэслэлгүй.

Хоёр. Д.Ганбатыг бүртгүүлэх өргөдлийн тухайд:

Ардчилсан намын дарга гэх С.Эрдэнийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Ардчилсан намын даргыг сонгох сунгааг товлон зарлах тухай” А/06 дугаар тушаалын хувьд:

Улсын дээд шүүхийн 2021 оны 04, 09 дүгээр тогтоол, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 12 дугаар тогтоолоор С.Эрдэнийн Ардчилсан намын даргаар бүртгүүлэх, цахим бүртгэлд бүртгэгдсэн бүртгэлийг сэргээх тухай хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байгаа тул С.Эрдэнийг тус намын дарга гэж үзэхгүй. Мөн Ардчилсан намын дүрмийн 5.17.4-т Намын даргын бүрэн эрхийг тоочин заасан бөгөөд үүнд “Намын даргын сунгаа/сонгуулийг товлон зарлах” эрх байхгүй. Тушаалын үндэслэлд заасан намын дүрмийн 5.17.1-д “Ардчилсан намын дарга нь намын тэргүүн бөгөөд Үндсэн дүрэм, бусад журмын хүрээнд тушаал, шийдвэр гаргана”, 5.17.2-т “Намын Даргын сонгуулийг дүрмийн дагуу явуулж, намын Их Хурлаас 4 жилийн бүрэн эрхтэйгээр ёсчлон батламжилна” гэсэн нь намын даргын статус болон түүний сонгогдох журмыг зохицуулсан ерөнхий заалт болохоос бус намын даргад сонгууль зарлах эрхийг олгосон зохицуулалт биш байна.

Намын дүрмийн 5.12.2-т “... Их хурлын ээлжит, ээлжит бус хуралдааныг ҮБХ-ны нийт гишүүдийн ердийн олонхи (50-аас дээш хувь)-ийн саналаар ... хуралдуулна” гэж заасан.

Ардчилсан намын Үндэсний бодлогын хороо нь 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр хуралдаж нийт 5 тогтоол гаргасны дотор 19 дүгээр тогтоолоор намын ээлжит бус XVI Их хурлыг товлон зарлахдаа дүрмийн дээрх шаардлагыг хангаагүй байна. Өргөдөлд хавсаргаж ирүүлсэн баримт болох Үндэсний бодлогын хорооны намрын хаалтын хуралдааны тэмдэглэлд “...Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны саналын эрхтэй, бүрэн эрх нь баталгаажсан 248 гишүүнээс танхимаар 87 гишүүн оролцож, цахимаар 99 гишүүн буюу нийт 186 гишүүн хуралдаанд оролцож байна. Ирц 75%-тай байгаа...” гэсэн боловч үүнийг нотлох баримт байхгүй, Үндэсний бодлогын хорооны бүрэн эрх нь баталгаажсан хэн гэдэг гишүүн ямар хэлбэрээр оролцсон нь тодорхойгүй.

Намын дүрмийн 5.22.5.10-т “ДоСХ-ны үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх ба шийдвэрээ тогтоолоор гаргана... Хуралдааны тэмдэглэлд дарга, хурлын тэмдэглэл хөтөлсөн ажилтан гарын үсэг зурж ...” гэж, 5.22.5.12-т “Хуралдааныг гишүүдийн 2/3-оос дээш буюу 10 ба түүнээс дээш гишүүний ирцтэйгээр эхэлж, ердийн олонхийн саналаар шийдвэрээ гаргана...” гэж тус тус заажээ.

Гэтэл 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр хуралдсан Дотоод сонгуулийн хорооны хуралдааны тэмдэглэл байхгүй, хэзээ, хаанаас томилогдсон хэн гэдэг, хэдэн гишүүн яаж оролцсон нь тодорхойгүй, тухайн хуралдаанаас гаргасан 4 тогтоолын хүчин төгөлдөр байдал нь тодорхойгүй байгаа нь дүрмийн дээрх шаардлагыг хангаагүй гэж үзнэ. Өргөдөлд хавсарган ирүүлсэн Дотоод сонгуулийн хорооны 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 11, 13, 14, 15 дугаар тогтоолд дарга Х.Алтанхуяг, дэд дарга Л.Нармандах гэсэн 2 хүн, цахим сонгуулийн графикт

Б.Лхагвасүрэн, Э.Энхмөрөн гэсэн хүн гарын үсэг зурснаас өөрөөр ирцийг нотлох баримт байхгүй.

Түүнчлэн Дотоод сонгуулийн хорооноос зохион байгуулсан “цахим сонгууль”-д оролцсон гишүүдийн нэрс байхгүй. Тус хорооны 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн “Цахим сонгуулийн дүнг нэгтгэж, өргөн мэдүүлэх тухай” 13 дугаар тогтоолын хавсралт болон цахим сонгуулийн дүнгийн нэгтгэл, график үзүүлэлт болон Ардчилсан намын ээлжит бус XVI Их хурлын тэмдэглэлд 79489 гишүүн санал өгсөн гэх боловч санал өгсөн гишүүдийн нэрс байхгүй нь сонгууль бодитой болсон эсэх нь эргэлзээтэй.

Мөн Ардчилсан намын ээлжит бус XVI Их хуралд оролцсон төлөөлөгчдийн ирцийн бүртгэл гэсэн баримтад танхимаар оролцсон гэх гишүүдийн гарын үсэг байхгүй, цахимаар хийсэн хурлын явцыг баталгаажуулсан баримт байхгүй нь “Намын шийдвэр гаргах зарчим”-ыг зохицуулсан тус намын дүрмийн 4.3.5-д “Хурлын ирц дараах байдлаар бүрдэнэ. Үүнд: 4.3.5.1-д “Бүх шатны намын байгууллагын хурлын хувьд Үндсэн дүрэм, бусад журамд өөрөөр заагаагүй бол таслах эрхтэй нийт гишүүдийн ердийн олонхи” гэж заасныг хангасан эсэх нь тодорхойгүй буюу уг шаардлагыг хангаагүй байна.

Иймд Д.Ганбатыг Ардчилсан намын даргаар бүртгүүлэх тухай өргөдлийг хангахаас татгалзав.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон

ТОГТООХ НЬ:

1.Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 11 дүгээр зүйлийн 11.1-д заасныг баримтлан Ардчилсан намын даргаар Л.Гантөмөрийг бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 11 дүгээр зүйлийн 11.1, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4-т заасныг тус тус баримтлан Ардчилсан намын даргаар Д.Ганбатыг бүртгүүлэх тухай С.Эрдэнийн өргөдлийг хангахаас татгалзсугай.

3.Өргөдөл гаргагч нараас улсын тэмдэгтийн хураамжид тус бүр төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧИД

Г.БАНЗРАГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ